

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/012/НА-СТА-ТТЗ

| | |
|---|--|
| Цахим хуудас: www.audit.mn | Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn |
| Хөвсгөл аймаг 2025 он | Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn |
| | Ахлах аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhорlooga@audit.gov.mn |
| | Аудитор: Л.Мөнх-Оргил Утас: 99039344 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgui@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 1/330
танай _____ -ны № _____ -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 52.9 сая төгрөг, үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 1,019.5 сая төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэж үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төсөвт төвлөрүүлэх 6 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 5.3 сая төгрөгөөр тасалсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 21 иргэнтэй холбоотой 42.5 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулаагүй зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Жаргалант сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 74.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

6725022210

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|-------|---|----------------|-----------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 1,027,721.9 | 2,018,389.9 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 574553.3 | 1,555,367.8 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 232,942.4 | 198,155.3 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 220,226.1 | 229,766.8 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 9а | 0.0 | 35,100.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 3,443,817.4 | 4,241,592.9 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 11а, 11б | 81,351.8 | 44,511.8 |
| 37300 | Урт хугацаат зээл | | 81,351.8 | 44,511.8 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 3,362,465.6 | 4,197,081.1 |
| 39200 | Биет хөрөнгө | | 3,210,988.0 | 4,045,628.4 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 151,477.6 | 151,452.6 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 4,471,539.3 | 6,259,982.8 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 7,090.1 | 88,538.7 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 7,090.1 | 88,538.7 |
| 41300 | Өглөг | 17а, 17б | 3,305.6 | 85,954.2 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 18а, 18б | 3,784.5 | 2,584.5 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 4,464,449.2 | 6,171,444.1 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 4,464,449.2 | 6,171,444.1 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 3,011,043.6 | 3,011,043.6 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 91,421.2 | 91,421.2 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 1,168,845.7 | 2,875,840.6 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 193,138.8 | 193,138.8 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 4,471,539.3 | 6,259,982.8 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------|---|-----------|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 2,719,517.2 | 4,375,353.6 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 849,999.0 | 1,844,991.1 |
| 110 | Орлогын албан татвар | | 377,544.6 | 860,163.5 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 404,154.4 | 860,163.5 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -26,609.8 | 0.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 69,370.1 | 29,372.7 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 403,084.4 | 955,454.9 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 267,938.9 | 1,024,877.2 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 267,938.9 | 1,024,877.2 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 1,601,579.2 | 1,505,485.3 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 2,375,105.7 | 2,668,358.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 2,375,105.7 | 2,668,358.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 2,301,206.8 | 2,588,381.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 506,383.9 | 792,522.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 63,280.8 | 98,151.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 44,908.6 | 663,053.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 73,494.0 | 132,424.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 53,124.7 | 84,641.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 6,540.0 | 6,957.8 |

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

| | | | |
|------|--|-----------|-------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 969,499.9 | 400,910.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 583,974.9 | 409,719.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 73,898.9 | 79,977.6 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 344,411.5 | 1,706,994.9 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,221.1 | 0.0 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 343,190.4 | 1,706,994.9 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------|--|-----------|------------------------------|------------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | | 2,595,710.6 | 5,255,656.2 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 849,999.0 | 1,844,991.1 |
| 110 | Орлогын албан татвар | | 377,544.6 | 860,163.5 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 404,154.4 | 860,163.5 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -26,609.8 | 0.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 69,370.1 | 29,372.7 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 403,084.4 | 955,454.9 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 54,724.7 | 48,545.5 |
| 1181 | Газрын төлбөр | | 16,832.1 | 11,226.4 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | | 331,527.6 | 895,682.9 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 144,132.4 | 1,910,307.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 144,132.4 | 1,910,307.8 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 1,601,579.2 | 1,500,357.3 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 2,310,657.0 | 4,012,252.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 2,310,657.0 | 4,012,252.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,856,345.8 | 3,932,274.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 559,742.7 | 887,981.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 78,522.2 | 131,464.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 45,988.6 | 663,673.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 103,554.4 | 158,146.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 51,057.0 | 85,381.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 6,540.0 | 6,957.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 924,881.4 | 1,834,312.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 86,059.5 | 164,355.5 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 454,311.2 | 79,977.6 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | | 285,053.6 | 1,243,404.2 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | | 27,985.0 | 262,589.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 27,985.0 | 262,589.8 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 27,985.0 | 262,589.8 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | | -27,985.0 | -262,589.8 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | | -60,000.0 | 0.0 |

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

| | | | | |
|------|---|--|-----------|-------------|
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | | 60,000.0 | 0.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | | 197,068.6 | 980,814.4 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 377,484.7 | 574,553.3 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 574,553.3 | 1,555,367.8 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
төгрөгөөр/

/мянган

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---------------------------------------|--|-----------------------|------------------------|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,135,891.6 | 0.0 | 4,135,891.6 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,135,891.6 | 0.0 | 4,135,891.6 |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | -14,632.9 | 0.0 | -14,632.9 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 343,190.4 | 0.0 | 343,190.4 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,464,449.2 | 0.0 | 4,464,449.2 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,464,449.2 | 0.0 | 4,464,449.2 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,464,469.2 | 0.0 | 4,464,449.2 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 1,706,994.9 | 0.0 | 1,706,994.9 |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 6,171,444.1 | 0.0 | 6,171,444.1 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
төгрөгөөр/

/мянган

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|--------|--|--------------|-----------------------------|------------|-------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,744,685.50 | 2,437,411.46 | 307,274.04 | 88.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,296,278.70 | 2,174,280.71 | 121,997.99 | 94.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,233,534.50 | 2,111,537.41 | 121,997.09 | 94.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 779,301.50 | 763,151.71 | 16,149.79 | 97.9 |
| 210101 | Үндсэн цалин | 711,174.80 | 510,880.99 | 200,293.81 | 71.8 |
| 210102 | Нэмэгдэл | 59,126.70 | 230,661.21 | 171,534.51 | 390.1 |
| 210104 | Урамшуулал | 9,000.00 | 21,609.51 | -12,609.51 | 240.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 97,295.90 | 93,804.50 | 3,491.40 | 96.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,083.80 | 63,549.78 | 2,534.02 | 96.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,803.00 | 7,564.40 | 238.60 | 96.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,242.50 | 3,809.24 | 2,433.26 | 61.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,560.60 | 4,436.21 | -2,875.61 | 284.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,606.00 | 14,444.87 | 1,161.13 | 92.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 679,938.70 | 661,053.54 | 18,885.16 | 97.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 64,250.00 | 58,379.78 | 5,870.22 | 90.9 |
| 210302 | Түлш, халаалт | 592,088.70 | 585,279.86 | 6,808.84 | 98.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,600.00 | 17,393.90 | 6,206.10 | 73.7 |

Аудитын код: ХӨА-2025/012/НА-СТА-ТТЗ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

| | | | | | |
|-------------|--|---------------------|---------------------|-------------------|--------------|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 71,489.10 | 70,141.11 | 1,347.99 | 98.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,700.00 | 5,700.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,169.10 | 38,530.74 | 638.36 | 98.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,540.00 | 4,445.00 | 95.00 | 97.9 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,080.00 | 6,625.72 | 454.28 | 93.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,000.00 | 14,839.65 | 160.35 | 98.9 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 133,664.10 | 119,343.24 | 14,320.86 | 89.3 |
| 210602 | Тавилга | 3,500.00 | 3,500.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 130,164.10 | 115,843.24 | 14,320.86 | 89.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,448.60 | 5,682.00 | 766.60 | 88.1 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,448.60 | 5,682.00 | 766.60 | 88.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 286,063.10 | 236,805.85 | 49,257.25 | 82.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 279,403.50 | 230,763.41 | 48,640.09 | 82.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,259.60 | 1,209.60 | 50.00 | 96.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,000.00 | 1,000.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 550.00 | 550.00 | 0.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 250.00 | 250.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,250.00 | 1,689.50 | 560.50 | 75.1 |
| 210807 | Газрын төлбөр | 1,350.00 | 1,343.34 | 6.66 | 99.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 179,333.50 | 161,555.47 | 17,778.03 | 90.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 137,933.50 | 120,155.47 | 17,778.03 | 87.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 41,400.00 | 41,400.00 | 0.00 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 62,744.20 | 62,743.30 | 0.90 | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 62,744.20 | 62,743.30 | 0.90 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 38,086.10 | 38,086.10 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 24,658.10 | 24,657.20 | 0.90 | 100.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 332,406.80 | 263,130.75 | 69,276.05 | 79.2 |
| 223001 | Бусад хөрөнгө | 332,406.80 | 263,130.75 | 69,276.05 | 79.2 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 116,000.00 | 0 | 116,000.00 | 0.0 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 116,000.00 | 0 | 116,000.00 | 0.0 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,744,685.50 | 2,559,414.21 | 185,271.29 | 93.2 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 271,887.50 | 0 | 271,887.50 | 0.0 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 271,887.50 | 0 | 271,887.50 | 0.0 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,880,065.20 | 2,453,964.61 | 573,899.41 | 130.5 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,880,065.20 | 2,182,077.11 | 302,011.91 | 116.1 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0 | 271,887.50 | 271,887.50 | 0.0 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 592,732.80 | 105,449.60 | 487,283.21 | 17.8 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 114,121.30 | 98,017.82 | 16,103.48 | 85.9 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,678.70 | 7,431.77 | 6,246.93 | 54.3 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 464,932.80 | 0 | 464,932.80 | 0.0 |

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

| | | | | | |
|-----------|---|-----------|------------|------------|-------|
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 73,854.83 | -73,854.83 | 0.0 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 227,678.99 | 227,678.99 | 0.0 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 59 | 59 | | 100.0 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 29 | 29 | | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 4 | 4 | | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18 | 18 | | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7 | 7 | | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 29 | 29 | | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 11 | 11 | | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10 | 10 | | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 8 | 8 | | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн |
|-------------|--|------------------------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 123,212.13 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 123,212.13 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 71,504.19 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,234.30 |
| 210302 | Түлш, халаалт | 34,473.64 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 91,542.53 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,648.78 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 91,542.53 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 1,275.75 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 60,579.66 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,542.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,669.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 51,707.94 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,234.30 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,234.30 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 34,473.60 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 34,473.60 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 123,212.10 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 123,212.10 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 91,542.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 31,669.60 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 аж ахуй нэгж, 2 тусгай сан нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан, 2 аж ахуй нэгж түүвэрт

хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудтай холбоотой зөрчил

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 22.5 сая төгрөгийн алдаа, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, орон тоо хэтрүүлэн ажилласан, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн, ахмадын сан байгуулаагүй 12.3 сая төгрөгийн 4 зөрчил илэрсэн. Аудитын явцад 22.5 сая төгрөгийн алдааг залруулж, дээрх зөрчилд 2 албан шаардлага, 2 зөвлөмжийг өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой зөрчил

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 247.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 199.8 сая төгрөгийн зардлын хоорондын тооцооны бичилтийг хийгээгүй алдааг залруулж, цэвэр дүнгээр тайлагнуулж, 87.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 2 зөвлөмжийг өгсөн байна.

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг зөрчил илрээгүй бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн болно.

3.1 Төлбөрийн акт

1. Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа Эрчимт идэр сум дундын ойн анги нь байгууллагын төсвөөс тус сумын соёлын төвийн ойн хандивт 1.0 сая төгрөг өгсөн байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10. *Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно* заалттай нийцэхгүй, *нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тус зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

3.2 Албан шаардлага

1. Эрчимт идэр СДОАнгийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд: Авто машин 39,000.0 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн ба худалдан авах ажиллагаанд баримтлах босго үнэ баримтлаагүй, зах зээлийн үнээс хэт өндөр үнээр худалдан авсан нь ашиг сонирхол дагуулсан байж болзошгүй байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай тогтоолтой нийцээгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Эрчимт идэр СДОАнги нь тайлант 2024 онд шилэн дансны цахим системд мэдээлэх бүх мэдээллийг оруулах мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.
- Их жаргалант тохижилт үйлчилгээний төв нь шилэн дансны цахим системд мэдээлэл оруулах цэс нээлгээгүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. *Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 5дугаар зүйлийн 5.1.Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна: 5.1.1.шилэн дансны бие даасан цэстэй байх;* гэсэн заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй.

3. Эрчимт идэр СДО анги, Жаргалант Их тохижилт үйлчилгээний төв нь Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайланг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4.Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ. 46 дугаар зүйлийн 46.2.Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана заалтуудтай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

Аудитын илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн өмнөх оны хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэл 35 иргэний 81.3 сая төгрөгөөс 14 иргэний 38.7 сая төгрөгийн авлагыг барагдуулсан. Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 21 иргэнтэй холбоотой 42.5 сая төгрөгийн авлага байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Аймгийн төсөв, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн боловч татварын орлогын нэр төрлөөр авч үзэхэд 6 нэр төрөл бүхий орлогын төлөвлөгөөг 5.3 сая төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмж өгөх.

3. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

Аудитын илрүүлэлт: Байгууллагын дотоод хяналт хариуцсан нэгж нь байгууллагын дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж илэрсэн алдаа зөрчилд зөвлөмжийг өгч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг батлуулахдаа Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1-д заасан чиглэлийг баримтлах, алдаа зөрчлийг арилгах хугацаатай зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг тооцож ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5."Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга

Аудитын код: ХӨА-2025/012/НА-СТА-ТТЗ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | |
|---------------------------------------|--|--------------|-----------------------------------|--------------|--------------------------|-----|-------------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Харьяа байгууллагуудын алдаа Жаргалант ЗДТГ | | | | | | | |
| Бараа материалын бүртгэлтэй холбоотой | 1 | 3.5 | 1 | 3.5 | | | 1 | 3.5 |
| Авлагын данстай холбоотой | 2 | 13.3 | 2 | 13.3 | | | 2 | 13.3 |
| Өглөгийн данстай холбоотой | 1 | 5.6 | 1 | 5.6 | | | 1 | 5.6 |
| Дүн | 4 | 22.5 | 4 | 22.5 | | | 4 | 22.5 |
| ТТЗ | 1 | 199.8 | 1 | 199.8 | | | 1 | 199.8 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|------|---------------|-----|-----------------|------|---------|------|--------------------------------------|-----|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн төвлөрүүлэн захирагчийн зөрчил | | | | | | | | | | | | |
| Орлогын төлөвлөгөө тасалсан | 1 | 5.3 | | | | | 1 | 5.3 | | | | |
| Хугацаа хэтэрсэн зээлийн авлага барагдуулаагүй | 1 | 42.5 | | | | | 1 | 42.5 | | | | |
| Төсвийн хөрөнгөөр хандив өгсөн | 1 | 1.0 | 1 | 1.0 | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны хууль, журам зөрчсөн | 1 | 39.0 | | | 1 | 39.0 | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангаагүй | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайланг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлээгүй. | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |

Аудитын код: ХӨА-2025/012/НА-СТА-ТТЗ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|---|----------|-------------|----------|------------|----------|-----------|----------|-------------|--|--|--|--|
| Дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дүн | 7 | 87.8 | 1 | 1.0 | 3 | 39 | 3 | 47.8 | | | | |
| Харьяа байгууллагуудын зөрчил /ЗДТГ/ | | | | | | | | | | | | |
| Өмнөх зөвлөмж хэрэгжүүлээгүй | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Орон тоо хэтрүүлэн ажилласан | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн | 1 | 12.3 | | | | | 1 | 12.3 | | | | |
| Дүн | 1 | 12.3 | | | 2 | 0 | 1 | 12.3 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|----------|---------------|-----|-----------------|----------|----------|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Ахмадын сан байгуулаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 2 | 0 | | | 1 | 0 | 1 | 0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БАТАЛГААЖУУЛСАН:
АУДИТОР



Л.МӨНХ-ОРГИЛ ОГНОО: